



Development  
Progress

## Судалгааны тойм Боловсрол

### УНАЛТААС СЭРГЭЛТЭД: МОНГОЛ УЛСЫН БАГААС ДЭЭШ ШАТНЫ БОЛОВСРОЛ

Якоб Энгель, Аннализа Приццон, Амгаабазарын Гэрэлмаа нар



Гэрэл зураг: © Tenzing Paljor/Asia Foundation

- Монгол Улсад 1994 онд сургуульд элсэж орсон хүүхэд дунджаар 7,7 жилийг боловсролд зарцуулж байжээ. 2010 он гэхэд энэхүү дундаж үзүүлэлт 14,3 жил болон нэмэгдэж, бараг хоёр дахин өсчээ.
- Дунд боловсролын хүртээмж дэх хот, хөдөөгийн ялгаа сүүлийн арван жилд бараг арилжээ. 2000 онд хөдөөд дунд сургуулийн хамран сургалтын цэвэр жин (NER) 75,6 хувь байсан бол хотод энэ үзүүлэлт 88,8 хувь байв. 2011 онд энэ ялгаа арилж, хөдөөд 90,2 хувь, хотод 89,9 хувь болсон байв.
- Өдгөө Монголын залуучуудын таван хүн тутмын гурав нь их дээд сургуульд суралцаж байгаа нь өндөр орлоготой улс орнуудын дундаж үзүүлэлттэй ойролцоо байна. 1993-аас 2010 оны хооронд оюутны тоо зургаа дахин өсчээ.

“Хөгжлийн ахиц дэвшил” төслөөс боловсруулж гаргасан энэ болон бусад материалыг [developmentprogress.org](http://developmentprogress.org) хаягаар орж үзнэ үү.

“Хөгжлийн ахиц дэвшил” төсөл нь хөгжлийн чиглэлээр хаана, ямар ахиц, дэвшил хэрхэн гарч байгааг хэмжиж, ойлгон, мэдээлэх зорилготой Хилийн чанад дахь Хөгжлийн Хүрээлэнгийн төсөл юм.

Хилийн чанад дахь Хөгжлийн Хүрээлэн бол олон улсын хөгжил, хүмүүнлэгийн асуудлаар хараат бус судалгаа явуулдаг Их Британийн тэргүүлэгч байгууллага юм. Нэмэлт материалыг [odi.org.uk](http://odi.org.uk) хаягаар орж үзнэ үү.



Гэрэл зураг: © Nick Farnhill


## Монголын багаас дээш шатны боловсролыг яагаад судлах болсон вэ?

Монгол Улс бол бага боловсролоос хойшх бүхий л шатны боловсролын хүртээмжийг өргөжүүлэх замаар хүүхэд, залуучуудынхаа дундах мэдлэг, чадварын ялгаатай байдлыг шийдвэрлэж эхэлсэн улс орны нэг томоохон жишээ юм. Төв Азийн шилжилтийн эдийн засагтай улс орнууд дундаас дунд, дээд боловсролд хамрагдагсдын тоо хамгийн ихээр буурсан улс болж байсан Монгол 20 жилийн дотор хурдацтай сэргэн, одоо энэ үзүүлэлтээрээ хөрш орнууд төдийгүй Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн улс орнуудтай эн зэрэгцээд байна.

Эдийн засаг даяаршсан өнөө үед үндэсний эдийн засгийн өсөлт, бүтээмжид хувь нэмрээ оруулахын тулд эзэмшсэн байх шаардлагатай ур чадвар, чадварын цэнэглэж өгөх багаас дээш түвшний боловсролыг иргэддээ тэгш хүртээмжтэй олгох нь үндэсний хөгжил, дэвшлийн нэг нөхцөл болжээ. Дунд болон түүнээс дээш шатны боловсролоор олж авч байгаа мэдлэг, чадвар нь үр нөлөөтэй, чадварлаг иргэний идэвх оролцоог хангах, залуучуудыг ажил хөдөлмөрт бэлтгэхэд чухал ач холбогдолтой юм. Багаас дээш түвшний боловсрол нь залуучууд, тэдний гэр бүлийг ядуурлаас гарахад тусалж чадна. Ялангуяа зах зээл улам л нарийн төвөгтэй ур чадвар эрэлхийлэх болж, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд залуучуудын бодитойгоор эзэмшиж авсан ур чадвар нийцэхгүй байгаа өнөө үед энэ нь бүр ч чухал асуудал юм.

“Сургуулиуд хүний гар дээр тавих бэлэн мөнгөгүй болж байсан үе бий. Энэ нь хөрөнгө мөнгө идэж шамшигдуулсан, буруу ашигласантай огт холбоогүй. Зүгээр л улсын төсвөөс мөнгө орж ирэхээ больсон... Сургуулиуд юу л олж чадна уу, бүр бартераар авсан мах, гурилаараа багш нарынхаа цалинг тавьж байсан” - Боловсролын салбарын мэргэжилтэн

Зураг 1: Сургуульд суралцах дундаж хугацаа, Монгол, Төв Азийн шилжилтийн эдийн засагтай улс орнууд, 1989-2011 он



Эх сурвалж: ЮНЕСКО-гийн Статистик Мэдээллийн Хүрээлэнгийн өгөгдөл (2012).

Тус судалгаагаар Монголын боловсролын гайхамшигтай сэргэлт, үүний дотор багаас дээш шатны боловсрол бүх нийтийн шахам хамрагдалттай болж, их дээд сургуулийн элсэлт бараг гурав дахин өссөн зэрэг амжилтыг судлахдаа доорх хоёр асуултыг онцлон үзлээ.

- Багаас дээш боловсролын хамран сургалт ийнхүү нэмэгдэхэд ямар хүчин зүйлс нөлөөлж, үүнд шаардлагатай санхүүжилтээ хэрхэн бүрдүүлсэн бэ?
- Боловсролын бусад асуудал болох чанар, тэгш байдал, нийцтэй байдал, мөн сургуулиас хөдөлмөрийн зах зээл рүү шилжих шилжилт хэрхэн бүрэлдэн төлөвшөөд байна вэ?

Монголын туршлага нь урьд өмнөхөөс илүү олон хүүхэд бага боловсролоо дүүргэж байгаа, цаашилбал дунд болон түүнээс дээш шатны боловсролынхоо тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхийг хүсэж буй бусад улс оронд ач холбогдолтой байж болно. Мөн тус улс 1990-ээд оны эхэн үеийн нийгэм, эдийн засгийн уналтаас хэрхэн

гарч сэргэсэн туршлага нь ижил төстэй нийгэм, эдийн засгийн цочрол, хямралд өртөөд байгаа болон мөн хүн амын сийрэг суурьшил, хатуу ширүүн цаг уур зэрэг удаан хугацааны сорилттой тэмцэж байгаа улс орнуудад хэрэгтэй мэдээлэл болох буй за.

## Ямар ахиц дэвшил гарсан бэ?

Монгол Улс 50 гаруй жилийн турш Зөвлөлтийн дагуул улсын хувьд ЗСБНХУ-ын тусламж дэмжлэгийг хүртэж, хүүхэд бүрт бага ангиас авахуулаад дээд сургууль дуустал бүх шатны боловсролыг үнэ төлбөргүй олгож байжээ. Зөвлөлт Холбоот Улсын задрал, түүнээс үүдсэн эдийн засгийн хямралын улмаас 1990-ээд оны эхээр боловсролын салбар уналтад орж, ялангуяа дунд болон дээд боловсролын хүртээмж хумигдсан. Багш нарын цалин, сургуулийн халаалт, гэрэл цахилгаан, засвар, үйлчилгээ, тоног төхөөрөмж, сурах бичиг зэрэгт зарцуулах мөнгө бага, заримдаа бүр байхгүй ч үе байсан.


“Монгол Улсын нэг гайхамшиг бол ... нүүдэлчдэд зориулсан сургууль байгуулж, хүн амынх нь 30-аас 40 хувь нь нүүдлийн амьдралтай хэвээр байхад л бараг хүн бүрт боловсрол олгож чадаж байгаа явдал юм.” -Боловсролын зөвлөх

Төв Азийн шилжилтийн эдийн засагтай бусад улстай харьцуулахад хүүхдийн сургуульд суралцах дундаж хугацаа (нэгдүгээр ангид шинээр элсэн орсон хүүхэд сургуульд тасралтгүй хэдэн жил сурч байгааг харуулсан дундаж) хамгийн эрс бууралттай гарч байсан Монгол 1990-ээд оны эхээр энэ үзүүлэлтээр бүс нутагтаа хамгийн сүүлийн байр эзэлж байсан бол одоо энэ бүсдээ тэргүүлэгч Казахстантай бараг эн зэрэгцээд байна (Зураг 1). Өнөөдөр Монголын дундаж сурагч дунд сургуулийн дараагийн шатны аль нэг боловсрол, сургалтад хамрагдаж байгаа явдал нь ЭЗХАХБ-ын гишүүн зарим оронтой ч өрсөлдөхүйц амжилт юм.

Хүүхдийн сургуульд суралцах дундаж хугацаа нэмэгдэж байгаа нь бага сургууль дүүргэн, дунд сургуульд элсэн орогчдын тоо хэмжээ буюу бага боловсролоос дунд боловсролд дэвшин орох

суралцагчдын тоо хэмжээ өссөнтэй зарим талаар холбоотой. 1997 онд дөнгөж 61 хувь<sup>1</sup> буюу тухайн үедээ сүүлийн 30 жилийн доод үзүүлэлтэд хүртэл унаад байсан дунд боловсролын хамран сургалтын бохир жин үүнээс зургаахан жилийн дараа 1990 оноос өмнөх түвшиндээ хүрч сэргэсэн юм. Түүнээс хойш энэ үзүүлэлт ерөнхийдөө тууштай өссөөр байна. 1990 оноос хойшх боловсролын тогтолцооны нэг гайхам онцлог бол 1990-ээд оны эхээр их, дээд сургууль төлбөртэй болсон ч гэлээ 1993 оноос хойш их, дээд сургуулийн хүртээмж хурдацтай өссөн явдал юм (хуудасны ар талд, Зураг 2). Өдгөө Монголын их, дээд сургуульд суралцаж буй эмэгтэй оюутны тоо эрэгтэйчүүдийнхээс бараг 10 хувиар илүү байгаа ба энэ нь нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээрээ Монголоос зургаа дахин илүү ЭЗХАХБ-ын дунджаас давсан үзүүлэлт юм.<sup>2</sup>

Зураг 2: Их, дээд сургуулийн хамран сургалт, Монгол, Төв Азийн хуучин Зөвлөлтийн Бүгд Найрамдах Улсууд, дунд орлоготой улс орнууд (ДОУО). 1980-2011 он



Эх сурвалж: Дэлхийн банкны Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд.

Тэмдэглэл: Төв Азийн хуучин Зөвлөлтийн Бүгд Найрамдах Улсуудын үзүүлэлтийг тооцож гаргахдаа Казахстан, Киргизстан, Тажикистан, Узбекистан улсын их, дээд сургуулийн хамран сургалтын хувь хэмжээг дундажлан авлаа. Эдгээр дөрвөн улсад хамааралтай бүрэн мэдээлэлтэй онуудыг л харууллаа. Туркменистан Улс 1991 оноос хойш мэдээлэл өгөөгүй шалтгаанаар хасагдав.

1 ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэнгийн өгөгдөлд үндэслэв.  
2 ЭЗХАХБ нь өндөр орлоготой эдийн засаг бүхий бүлэг улс орны жишиг болгож үздэг 34 өндөр орлоготой гишүүн улсаас бүрддэг.

Мөн багаас дээш шатны боловсрол 1990-ээд оны эдийн засгийн шилжилтийн эхэн үетэй харьцуулахад илүү тэгш хүртээмжтэй болсон байна. Өрхийн орлого нь сургуульд суралцах эсэх шийдвэрт хамгийн ихээр нөлөөлж буй хүчин зүйл хэвээр байгаа ч гэлээ 1990-ээд оны эхэнтэй харьцуулахад ядуу болон нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүд багаас дээш шатны боловсролд элсэн орж, төгсөх магадлал нэмэгджээ. 2000 он гэхэд дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин хөдөөд 75,6 хувь, хотод 88,8 хувь байсан бол 2011 он гэхэд зөрүү нь арилж, хөдөөд 90,2 хувь, хотод 89,9 хувьд хүрсэн юм.

## Ямар хүчин зүйлс өөрчлөлтийг авчирсан бэ?

Монголын нийт эдийн засгийн ерөнхий сэргэлт нь энэ улсын багаас дээш шатны боловсрол сэргэх суурь нөхцөл болж өгсөн бол гарсан ахиц дэвшил ийм өргөн цар хүрээтэй байсныг үндсэн дөрвөн хүчин зүйлээр тайлбарлаж болох байна.

1. Багаас дээш шатны боловсрол эрэлт ихтэй, үнэлэмж өндөртэй.
2. Монгол Улсын Засгийн газар боловсролд хөрөнгө оруулах замаар боловсролын үйлчилгээг өргөжүүлсэн.
3. Бодлогын шинэчлэл хийж, хүрч үйлчлэхэд хэцүү хүн амд үйлчилгээг хүргэж байна.
4. Хөгжлийн албан ёсны түншүүдээр дамжуулан гадаадын тусламж дэмжлэгийг татаж байгаа зэрэг болно.

### 1. Багаас дээш шатны боловсрол эрэлт ихтэй, үнэлэмж өндөртэй

Монгол гэр бүлүүд хүүхдээ сургуульд явуулахын тулд багагүй зүйлс золиослоход бэлэн байдаг бөгөөд энэ судалгааны явцад бидний уулзаж ярилцсан олон хүн боловсролыг чухал үнэт зүйл, хөрөнгө гэж үздэгээ хэлж байлаа. Боловсролын

Зураг 3: Дунд сургуулийн багш, сурагчийн тоон харьцаа



Эх сурвалж: Нэг багшид ногдох сурагчийн тоо

нэгэн мэргэжилтэн “Бүх эцэг эх үр хүүхэддээ аль болох сайн боловсрол олгохыг үнэхээр хүсдэг юм шиг санагддаг. Алслагдсан хөдөө нутгийн малчин айлуудаас эн тэргүүний хэрэгцээг нь асуухад “бүх хүүхдээ боловсролтой болгох” гэж хариулах явдал олон гарч байсан” гэж ярьж байлаа. Дунд болон дээд боловсролын аль аль нь чухал хөрөнгө, үнэт зүйл гэж үздэг байна. Тухайлбал, малчин өрхүүд авсан зээлийнхээ 67 хувийг боловсролд зарцуулж байгааг Дэлхийн Банкны судалгаагаар (2010) тогтоожээ.

Боловсрол олгоход чиглэсэн дэмжлэг өрх бүлийн түвшнээр хязгаарлагддаггүй ажээ. Аль нам эрх барьж байгаагаас үл хамааран боловсролын асуудал төрийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, сонгуулийн кампанит ажил, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байнга томоохон байр эзэлж байгаагаар нь энэ улсын боловсролд өгч байгаа ач холбогдлыг хэмжиж болно.

Соёлын үнэлэмжээс гадна боловсрол олох нь эдийн засгийн үр ашиг өгч байгааг Монголын залуучуудын дунд хийсэн боловсролын өгөөжийг тодорхойлох судалгааны дүн баталж байна. Дарь, Суруга нарын 2006 онд хийсэн боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох анхны судалгаагаар сургуульд нэмж суралцсан нэг жил бүр нь 7,2 хувийн

“Нүүдэлчин монголчууд боловсролтой, бичиг үсэгтэй хүмүүсээ хамгийн ихээр хүндэлж ирсэн нь бидний соёлын онцлог бөгөөд боловсрол бидний хувьд нийгмийн байр сууриа бэхжүүлэх, ахиулахад тус болж ирсэн ... 1970-аад онд бичиг үсэггүй, сургуульд сураагүй гэдгээсээ хүмүүс ичдэг байсан. Өнөөдөр ч гэсэн Монголд бараг хүн бүр, орон гэргүй хүмүүс ч гэсэн сонин уншдаг.” -Улсын боловсролын байгууллагын захирал

ашиг авчирч байгааг тооцоолж гаргасан ба энэ нь шилжилтийн эдийн засагтай ихэнх улсаас өндөр үзүүлэлт юм. Тэд мөн сургуульд нэмж суралцсан нэг жил бүр нь 35-аас доош насны залуучуудын цалинг 9 хувиар нэмэгдүүлэх нөлөөтэй байгааг тооцоолжээ. Пастор (2010) мөн боловсролын түвшин ахихтай зэрэгцээд цалин орлого нэмэгдэж байгааг баталж, дээд боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр ашиг 9,5 хувь байхад ерөнхий боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр ашиг 4,2 хувь байгааг тооцоолон гаргажээ. Эдийн засгийн шилжилтийн дараах хямрал саарахын хэрээр багаас дээш шатны боловсрол эзэмшихтэй холбоотой гарах дарамт ачаалал мөн буурч, сургууль завсардаад байсан олон хүүхэд эргэж сургуульдаа орсон юм.

## 2. Монгол Улсын Засгийн газар боловсролд хөрөнгө оруулах замаар боловсролын үйлчилгээг өргөжүүлсэн

Аж үйлдвэрлэлийн сэргэлт, шинээр нээгдсэн эрдэс баялгийн нөөцдөө түшиглэн Монголын эдийн засаг уналтаас гарч, төрийн хөрөнгө нөөцийн хэмжээ өссөн. Татвар хураалтын үр ашигтай тогтолцоо бүрдүүлснээр төрд орох орлого улам нэмэгдсэн байна (Дэлхийн Банк, 2010, х.3). Дэлхийн Банкны мэдээллийн баазаас харахад, сүүлийн жилүүдэд боловсролын салбарт зарцуулсан улсын төсвийн ДНБ-д эзлэх хувь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн дунджаас илүү гарсан өндөр үзүүлэлттэй байна (Номхон далайн зүүн бүсд 2008 онд 3,8 хувь байсан бол Монгол Улс 2005-2009 оны дунджаар 4,9 хувьтай байв). Энэ нь боловсролын салбарт илүү их нөөц хуваарилагдаж байгаа гэсэн үг юм.

Монгол Улс боловсролын салбартаа илүү их хөрөнгө хуваарилж байсны үр дүнд тээвэр, холбооны дэд бүтцийн зэрэгцээ сургууль барих томоохон төслүүдийг санхүүжүүлж чадсан юм. Хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын их шилжилт хөдөлгөөний хариуд боловсролын салбарын төлөвлөгчид том хот, томоохон суурин, хотын захгаар шинэ сургуулиуд барьж байгуулж байв. Түүнчлэн сургуулийн барилгуудыг илүү аюулгүй, тухтай, эрчим хүчний хэмнэлттэй болгон засварлах чиглэлд томоохон ажлууд хийгдсэн.

1990-ээд онд огцом багассан дунд сургуулийн багшийн тоо сүүлийн жилүүдэд өсч байгаа нь ажиглагдаж байна (Зураг 3-ыг үзнэ үү).

Багш бол хамгийн нэр хүндтэй мэргэжлийн нэг бөгөөд заримдаа багшийн цалин эмчийхээс ч өндөр байдаг тухай манай ярилцлагад оролцсон хүмүүс онцолж байсан юм. Ялангуяа хөдөө орон нутагт баталгаатай, сайн цалинтай цорын ганц ажлын байр бол багшийн ажил байх нь олонтаа. Хөдөө, хотоор нь ялгаж гаргасан нарийн тоо байхгүй ч Боловсролын яамны статистик мэдээгээс үзэхэд бүх 21 аймаг, нийслэл хотод сүүлийн жилүүдэд багшийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

Эцэст нь, дээд боловсролын түвшинд сургалтын төлбөр нэвтрүүлэхтэй зэрэгцээд хувийн хэвшлийн оролцоо өсөн нэмэгдсэн явдал нь элсэгчдийн тоо огцом нэмэгдсэн ч төсвийн зардлыг хязгаарлахад тус дэм болжээ.

## 3. Бодлогын шинэчлэл хийж, хүрч үйлчлэхэд хэцүү хүн амд үйлчилгээг хүргэж байна

Монгол Улсын боловсролын шинэчлэлийн зорилго, зорилтууд 1991 оны Боловсролын тухай хууль, 1993 оны Боловсролын салбарын мастер төлөвлөгөө, 1995 оны Бага, дунд боловсролын тухай хууль, 1992 оны шинэ Үндсэн хууль зэрэг хууль тогтоомж, стратегийн баримт бичигт тусан, баталгаажсан байдаг. Эдгээр нь Вашингтоны зөвшилцлийн загварын үндсэн зарчмуудыг баримталсан, Вайдманы (2001) хэлснээр “Оросын загвараар нарийн төрөлжүүлэн, дээд зэргээр хэсгэлэн хуваарилсан тогтолцооноос илүү уян хатан тогтолцоо руу шилжиж, үүний дотор бүтцийг илүү оновчтой болгож, төвлөрлийг сааруулах замаар боловсролын үр ашиг, үр өгөөжийг бүх шатандаа сайжруулах”-д чиглэсэн зорилтууд байсан юм.

Эдгээр хууль тогтоомж нь бага, дунд боловсролыг заавал эзэмших ёстой үнэ төлбөргүй боловсрол болохыг дахин баталгаажуулсан ч үзэл баримтлалын хувьд социализмаас илүү ардчилсан, хүмүүнлэг хандлага руу шилжсэн утга агуулгатай болж чадсан юм. 1993 оны Боловсролын салбарын мастер төлөвлөгөө нь хамгийн их нарийвчлалттай стратегийн баримт бичиг болжээ. Хандивлагчдын гүйцэтгэсэн салбарын үнэлгээнд тулгуурлан боловсруулагдсан тус баримт бичиг нь тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх зорилгод чиглэж байсан ба ер нь тухайн үед хандивлагчдын дэмжин хэрэгжүүлж байсан боловсролын олон шинэчлэлийн үзэл санаа, зорилтыг тусгасан юм (жишээлбэл, Самофф, 1996 судалгааг үз). Мастер төлөвлөгөө нь боловсролын санхүүжилтийн тогтолцоог төсвийн хэмжээ, санхүүжилтийн механизм, хувийн хэвшлийн оролцоог нэмэгжүүлэх зэрэг чиглэлээр өөрчлөн зохицуулалт хийхэд бодит нөлөө үзүүлсэн юм. Харин төвлөрлийг сааруулах зэрэг бусад зорилтыг сайндаа л хэсэгчлэн биелүүлж чадсан гэж үзэх үндэслэлтэй.

Сургалтын хөтөлбөрийн талаарх хамгийн том шинэчлэлийг 2003 онд хийсэн ба энэ нь төрийн болон хувийн хэвшлийг аль алиныг нь хамарсан байна. Тухайн үеийн боловсролын өөрчлөлт шинэчлэлийн хүрээнд сургуульд суралцах хугацааг 2004 онд 10-аас 11 жил болгон сунгаж, 2008 онд 12 жил болгожээ. Энэ алхам нь сургалтын хөтөлбөр болон боловсролын түвшин бүрийн стандартыг шинэчлэх шаардлага бий болгосон юм. ЮНЕСКО-ийн үнэлгээгээр шинэ тогтолцоо нь “онолын чиг хандлагатай сургалтаас амьдралын чиг хандлагатай сургалт руу шилжих, сургалтын хөтөлбөр нь даяаршсан дэлхий ертөнцөд суралцаж, амьдрахад шаардлагатай чадварыг

сурагчдад олгох зорилтод бүхэлдээ төвлөрч бай[в]” (ЮНЕСКО, 2011, х.10). Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Боловсролын салбарын мастер төлөвлөгөө (2006-2015) нь чанартай боловсролын хүртээмж дэх ялгаатай байдлыг багасгах; чанартай боловсролын үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах; боловсролын бодлого боловсруулах, менежментийн чадавхийг бэхжүүлэх гэсэн гурван үндсэн зорилготой болно.


Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг хөдөөгийн ард иргэдэд боловсролын үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийн тулд авч хэрэгжүүлж болох хамгийн үр дүнтэй арга хэмжээ нь дотуур байртай сургууль барьж, сургуулийн дотуур байруудыг улсын төсвөөс санхүүжүүлэх явдал гэж үздэг ажээ. Сүүлийн жилүүдэд

хандивлагчдын хүсэл зорилгоор мөн бага сургуульд суралцаж байгаа эмзэг бүлгийн хүүхдүүдийг анхаарч, тэднийг сургууль завсардуулалгүй дараа дараагийн шатны боловсролд дэвшин суралцах, улмаар хөдөлмөрийн зах зээлд шилжихэд нь дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Мөн эмзэг бүлгийн хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох зорилготой хөтөлбөрүүдийг ч хандивлагчид санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөр нь багаас дээш шатны боловсролд шууд чиглээгүй ч гэлээ эмзэг бүлгийн хүүхдүүдийн дунд сургуульд дэвшин суралцах боломжийг баталгаажуулж байгаа юм.<sup>3</sup> Сургуулиуд хүүхдийнхээ тоогоор санхүүждэг болсноор хүүхдүүдээ бүрэн элсүүлж, завсардуулахгүй байх бас нэг хөшүүрэгтэй болж байна.



Гэрэл зураг: © Khasar Sandag/World Bank

3 Үүнд 37 цэцэрлэг барьж, хөдөөгийн болон хотын захын бүсийн эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулсан сургуулийн өмнөх боловсролын хувилбарт үйлчилгээг бий болгох зорилгоор Олон улсын боловсролын төлөөх түншлэл (Global Partnership for Education)-ээс олгосон 10 сая долларын тусламж багтсан болно.



Гэрэл зураг: © Khasar Sandag/World Bank

#### 4. Хөгжлийн албан ёсны түншүүдээр дамжуулан гадаадын тусламж дэмжлэгийн татаж байна

1990-ээд оны дунд үеэр Зөвлөлтийн дэмжлэг тасалдсанаас үүдэлтэй тусламжийн хоосон орон зайн нэг хэсгийг Хөгжлийн албан ёсны тусламжийн хороо (ХАЁТХ буюу англиар DAC)-нд багтдаг уламжлалт хандивлагчид болон олон талт хандивлагчид нөхөн дүүргэсэн юм. 1980-аад онд нэг хүнд хэмжээгээрээ 10 америк доллар ч хүрдэггүй байсан ХАЁТХ-ны хандивлагчдын албан ёсны хөгжлийн тусламж 1990-2000-аад онд 80-100 америк доллар болж огцом өсөн, 2009 онд 137 америк доллар буюу оргил цэгтээ хүрч, нэг хүнд ногдох ДНБ-ий 8 хувьтай тэнцэж иржээ.

Монгол бол хуучин төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай улс орнуудын дотроос гадаад хандивлагчдын тусламжтайгаар өргөн цар хүрээтэй боловсролын төсөл хэрэгжүүлсэн бүс нутгийн анхны орон юм. Хандивлагчдаас ялангуяа боловсролын дэд бүтцийг хөгжүүлэхэд олгосон хөрөнгө нөөц, тэдний өгсөн бодлогын зөвлөмж нь боловсролын салбарын сэргэлтэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Боловсролын салбарт зориулж олгосон хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээ 2000-аад онд өссөн (2001 онд 9 хувь байснаа 2004 онд 26 хувь болсон) нь Мянганы дээд хэмжээний уулзалтаар хандивлагчид нийгмийн салбарт дэмжлэгээ чиглүүлэхээр тохиролцсонтой холбоотой билээ.

Монголын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу хийсэн шилжилт, боловсролын салбарыг бүхэлд нь хамарсан хурдацтай өөрчлөлт шинэчлэл нь зөвхөн дотоодын шахалт шаардлага төдийгүй гадаад орчны өөрчлөлт, үүний дотор Өрнөдийн хандивлагчдын үүрэг роль илүү хүчтэй болсонтой холбоотой ажээ. Боловсролын шинэчлэлийн гол тулгуур багана болох төрийн оролцоог багасгах, төлөвлөлт, санхүүжилтийн төвлөрлийг сааруулах, дээд боловсролыг төлбөртэй болгох, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг бодлого нь шилжилтийн эдийн засагтай болон их өртэй бага орлоготой бусад олон улс оронд (ялангуяа хандивлагчдын оролцоо ихтэй улс орнууд) хэрэгжүүлсэн боловсролын шинэчлэлтэй ижил төстэй байгаа юм. Гадаадын хандивлагчид *"Монголд өрнөж буй нийгэм, улс төрийн үйл явцын мөн чанарт хамгийн их нөлөө үзүүлэх боломж олгоно гэж зөв төсөөлсний үндсэн дээр боловсролын салбарт хөрөнгө оруулахыг хүсэн, эрэлхийлж байгаа"*-г Супрунова (2007) ажиглан тэмдэглэжээ. Ялангуяа, Азийн хөгжлийн банк (АХБ) тус салбарт тулгараад байсан бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлд Засгийн газар, хөгжлийн бусад түнштэй хамтран идэвхтэй ажилласан билээ.

#### Ямар бэрхшээл тулгарч байна вэ?

Монголын боловсрол хорин жилийн сэргэлт, шинэчлэлийн үр дүнд тодорхой амжилтад хүрсэн ч гэлээ зарим хуучин сорилт бэрхшээл шийдвэрлэгдээгүй үлдсэний дээр шинэ асуудлууд гарч ирж байна. Энэ судалгааны хүрээнд хийгдсэн хараат бус үнэлгээ, авсан ярилцлагуудаас дүгнэхэд багаас дээш бүх боловсролын шатанд Монголын залуучуудын үзүүлж буй сурлагын амжилт санаа зовох түвшинд байгаа бөгөөд ахиц дэвшил гарч байгаа бол хэтэрхий удаан байгааг онцлох байна. Одоо хэрэгжиж буй сургалтын хөтөлбөр нь орчин үеийн боловсролын стандартад нийцэхгүй байгааг салбарын дүн шинжилгээ (ЮНЕСКО, 2011) харуулсан бол хот, хөдөөгийн сурагчдын сурлагын амжилтын түвшин маш их ялгаатай байгааг саяхан үндэсний хэмжээнд явуулсан үнэлгээ харууллаа. Түүнчлэн дээд боловсролын олон байгууллагын сургалтын чанар, олгож буй зэрэг цолын харьцангуй чанар зэрэгт анхаарах зүйл их байна.

Багаас дээш шатны боловсролын чанар сул, нийц муу байгаа явдал нь хөдөлмөрийн зах зээл дээр ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн гажуудал үүсэх шалтгаан болоод байна. Үүнийг Дэлхийн банк (2010) тайландаа тодорхой дурдаад, Монголын дээд боловсролын салбарын тоон өсөлт нь Монгол Улсын олон улс дахь өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр болж чадах төгсөгчдийг бэлтгэн гаргах үр дүн авчирч чадахгүй байгааг онцолжээ. Их, дээд сургууль төгсөгчдийн 36 хувь нь л төгссөнөөсөө хойш нэг жилийн дотор ажилд орж байхад техник, мэргэжлийн сургалтын байгууллага (МСҮТ) төгсөгчдийн 60 хувь нь ийм амжилт үзүүлж байгаа юм. Энэ дүнг ашиглан, уул уурхай хөгжин цэцэглэхийн зэрэгцээ үйлчилгээний салбарт ажиллах хүчний хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж буй Монголын эдийн засагт хэрэгцээ шаардлагатай байгаа ур чадварыг аль болох олон залуучуудад эзэмшүүлэх зорилгоор 2009 оноос хойш техник мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг шинэчлэн, өргөжүүлэх ажил эрчимтэй хийгдэж байна.

Эцэст нь онцлоход, Монголын эдийн засгийн өсөлт бол 2016 он гэхэд Монголын ДНБ-ий 50 хувийг үйлдвэрлэх төлөв (НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн комисс, 2012) бүхий уул уурхайн салбарын хөгжилтэй шууд холбоотой. Гэхдээ эрдэс баялгийн экспортоос ихээхэн хамааралтай байх нь тус улсыг түүхий эдийн үнийн уналтад өртөмтгий болгож байна. Энэ нь эргээд татварын орлогод нөлөөлж, бүх нийтийн боловсролын санхүүжилтийг шууд бусаар хүндрүүлж мэднэ.

## Монголоос суралцах зүйлс

Монголын багаас дээш шатны боловсролд гарсан ахиц дэвшил нь аливаа улс орон өөрчлөгдөн буй нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, эдийн засгийн хямрал, хүн амзүйн өөрчлөлт, эрчимтэй хотжих үйл явц, байгаль орчинд үзүүлэх ачаалал зэрэгт хэрхэн зохицон өөрчлөгдөж болохыг харуулж буй жишээ юм. Монголд амжилттай хэрэгжсэн зүйлс нь ижил төстэй сорилт бэрхшээлтэй тулгараад байгаа бусад улс орон, мөн бага боловсролоо дүүргэн дунд боловсролд дэвшин орж байгаа хүүхдийн тоо нэмэгдсэний улмаас төсөвт учрах ачааллыг зохицуулах бодлогын шийдэл эрэлхийлж буй улс орнуудад туршлага болох юм.

- **Боловсролын үйлчилгээг хот, хөдөөгийн хүн амзүйн өөрчлөлтөд нийцүүлэн зохицуулах шаардлагатай.** Монгол Улс нүүдлийн мал аж ахуйд суурилсан эдийн засгаас аж үйлдвэрийн суурьтай эдийн засаг руу шилжихэд боловсролын салбар үүнд дасан зохицох шийдэмгийн алхам хийсэн. Хотын захын бүсүүдийн боловсролын дэд бүтцийг нэмэгдүүлэх чиглэлээр маш их зүйл хийж бүтээхийн зэрэгцээ хөдөө орон нутагт дунд боловсролын хүртээмжийг дэмжин ажиллаж иржээ. Гэхдээ хөдөө орон нутгийн залуучуудад дээд боловсролыг илүү хүртээмжтэй болгох, үүний тулд, жишээлбэл, сургуулиудыг нэгтгэн чамбайруулах, дотуур байрны багтаамжийг нэмэгдүүлэх, алслагдсан орон нутагт очиж ажиллах багшийн урамшууллыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч болох юм.
- **Салбарыг бүхэлд нь хамарсан бодлого, хандлагаар боловсролын тэгш байдлыг**

### **нэмэгдүүлж болох хэдий ч зорилтот бүлгийн хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай.**

Монгол Улс боловсролын үйлчилгээгээ бүхэлд нь тэлэхийн зэрэгцээ хүрч үйлчлэхэд хамгийн хэцүү эмзэг бүлгийнхэнд үйлчилгээгээ хүргэх тал дээр онцгой хүчин чармайлт гаргасны ачаар боловсролын тэгш байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр багагүй амжилт олж чадсан улс юм. Ижил төстэй сорилт бэрхшээлтэй тулгарч буй бусад улс оронд зөвлөхөд, боловсролын салбарын нийтлэг бодлогодоо тэгш байдлыг хангахад чиглэсэн зохицуулалт суулгаж өгөхийн зэрэгцээ өнөөг хүртэл анхаарлын гадна явж ирсэн үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг бүлэгт чиглэсэн зорилтот арга хэмжээг тусгах нь зүйтэй.

- **Төвлөрлийг сааруулах хүчин чармайлтыг сургуулийн түвшиндээ хариуцлагыг дээшлүүлэх сэдэл төрүүлэх үр нөлөөтэй санхүүгийн болон бусад тодорхой урамшууллаар дэмжих.** Монгол Улсын төвлөрлийг сааруулах бодлого нь төвлөрсөн шийдвэр гаргах илүү танил, хуучин соёлтой тэмцээр ирсэн. Энэ тэмцлийг нэвтлэн гарч ирсэн бодлого бол нэг сурагчид ногдох хэмжээгээр төсөв хуваарилах томьёо болсон бөгөөд санхүүжилтийн энэхүү аргачлал нь сургууль бүрт хамран сургалтаа нэмэгдүүлэх, завсардалтаа бууруулах хөшүүрэг болж чадсан юм. Хуваарилалтын ийм томьёонууд нь хүчин чадлаа бүрэн дүүрэн ашиглаж, завсардалтыг бууруулах сонирхлыг сургуулиудад төрүүлэх ч гэлээ хуваарилалтын

томьёо нь анхнаасаа тэгш байдлыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулагдсан байх хэрэгтэй.

- **Боловсролын салбар ялангуяа дээд боловсролын түвшинд хувийн хэвшлийн боловсролын байгууллага, хувийн салбарын ажил олгогч нартай илүү идэвхтэй хамтран ажиллах зорилт дэвшүүлэн тавих нь зүйтэй.** Монголд хувийн хэвшлийн эзлэх орон зай дунд боловсролын түвшинд хязгаарлагдмал ч гэлээ дээд боловсролын түвшинд маш их өргөжин тэлээд байгаа юм. Дээд боловсролын үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоо нээгдсэнээр их дээд сургуульд суралцах монгол залуусын тоо ихээр нэмэгдсэн ч боловсролын чанартай холбоотой багагүй асуудал гарах болжээ. Боловсролын салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэхийн хэрээр тэдний сургалтын чанарт хатуу нарийн мониторинг хийж, олгож буй эрдмийн зэрэг, цол нь чанарын шаардлага хангаж байгаад хяналт тавихын зэрэгцээ төгсөгчдийг зохимжтой ажлын байраар хангахын тулд сургуулиас

ажлын байр руу шилжих шилжилтийг дэмжих чиглэлээр хувийн салбарын ажил олгогчидтой илүү нягт хамтран ажиллах шаардлагатай болно.

Монгол Улс сорилт бэрхшээлийг даван туулах чадвараа харуулж чадлаа. Төр, засгийн бодлогын үр дүнд бий болоод байгаа багаас дээш шатны боловсролын тэлэлт нь боловсролд онцгой анхаарч ирсэн түүхэн уламжлал, түүнээс дутахгүй өндөр эрэлттэй шууд холбоотой. Дээд боловсрол төлбөртэй болж, олон их, дээд сургуулийн сургалтын чанар эргэлзээтэй байсаар байтал их, дээд сургуульд суралцагсдын тоо бараг гурав дахин өссөн явдал нь Монгол гэр бүлүүд дээд боловсролыг өндөр ач холбогдол өгч байгаагийн нэг илрэл юм. Ийм их хүсэл тэмүүлэл, боловсролын хүртээмжийн эрчимтэй өсөлттэй хосолсноор Монгол Улс хүн бүрт чанартай сайн дунд ба түүнээс дээш шатны боловсрол олгох хүчин чармайлтдаа урьд өмнө байгаагүй ахиц гаргах гарааны нөхцлөө бий болгож байгаа хэрэг юм.

Энэхүү тойм нь судалгааны тайлангийн хураангуйлсан хувилбар бөгөөд [www.developmentprogress.org](http://www.developmentprogress.org) хуудсаар дамжуулан олон нийтийн хүртээл болгож буй “Хөгжлийн ахиц дэвшил” цувралын нэг хэсэг юм.

“Хөгжлийн ахиц дэвшил” төсөл нь хөгжлийн чиглэлээр гарч буй ахиц дэвшлийг илүү сайн ойлгож, хэмжиж, мэдээлэх зорилготой дөрвөн жилийн судалгааны төсөл юм. 24 судалгаанаас бүрдсэн төслийн эхний үе шатыг үргэлжлүүлж буй энэхүү хоёр дахь үе шат нь улс орнуудыг дамнан салбар салбарт гарч байгаа хөгжил дэвшлийг судалж, сүүлийн хорин жилийн хугацаанд ямар амжилт гарч, үүнд юу нөлөөлснийг баримт, нотолгоо ашиглан тайлбарлан, танилцуулж байна.

Энэ тойм нь Билл ба Мелинда Гэйтсийн сангийн санхүүжилтээр гүйцэтгэсэн судалгаанд үндэслэсэн болно. Энд багтсан үнэлгээ, дүгнэлтүүд нь зөвхөн зохиогчдын санал дүгнэлт бөгөөд Билл ба Мелинда Гэйтс сангийн байр суурь, бодлогыг төлөөлөхгүй болно.

---

#### Хилийн чанад дахь хөгжлийн хүрээлэн

Блакфраерз гудамжны 203 тоот  
Лондон хот, SE1 8NJ

Тус хүрээлэн хязгаарлагдмал эрхтэй болно.  
Англи, Вэльс Улсад бүртгэлтэй  
Бүртгэлийн № 661818  
Тусламжийн байгууллагын № 228248

#### Холбоо барих мэдээлэл

[developmentprogress.org](http://developmentprogress.org)  
[developmentprogress@odi.org.uk](mailto:developmentprogress@odi.org.uk)  
Утас: +44 (0)20 7922 0300

**Манай цахим мэдээллийн хуудсыг цахим шуудангаар хүлээж авах хүсэлтэй байгаа бол бүртгүүлнэ үү**  
[developmentprogress.org/sign-our-newsletter](http://developmentprogress.org/sign-our-newsletter)

#### Биднийг Twitter-ээр дагана уу

[twitter.com/dev\\_progress](https://twitter.com/dev_progress)

#### Хариуцлага хүлээхээс татгалзах тухай мэдэгдэл

Энэ судалгааны материалд туссан үнэлгээ дүгнэлт нь зохиогчдын байр суурь бөгөөд ХЧХХ-ийн үзэл бодлыг заавал илэрхийлэх албагүй.

© Хилийн чанад дахь хөгжлийн хүрээлэн, 2014 он.  
Уншигчид ашгийн бус зорилгоор энэ материалаас иш татаж, эсвэл хуулбарлан ашиглаж болно. Онлайн аар ашиглах бол “Хөгжлийн ахиц дэвшил” төслийн вэбсайт дээрх эх материалын холбоосыг ашиглана уу. ХЧХХ зохиогчийн эрх эзэмшигчийн хувьд үүсмэл бүтээгдэхүүнд ХЧХХ-г дурьдах, материалын нэг хувийг ирүүлэхийг танаас хүсэж байна.

## Ишлэл

- Darii A., Suruga T. (2006) ‘Economic returns to schooling in transition: A case of Mongolia’. *GSICS working papers*, 9 September. Kobe: Kobe University Graduate School of International Cooperation Studies. Available at: <http://www.research.kobe-u.ac.jp/gsics-publication/gwps/2006-09.pdf>
- Pastore, F. (2010) ‘Returns to Education of Young People in Mongolia’. *Post-Communist Economies* 22(2): 247-265.
- Samoff, J. (1996) ‘Which priorities and strategies for education?’. *International Journal of Educational Development*, 16(3): 249-271.
- Suprunova, L.L. (2007) ‘Education in Mongolia: The Difficulties and Achievements of the Period of Transition’. *Russian Education and Society*, 49(1): 78-97.
- UNESCAP (2012) ‘Country briefing note: Mongolia’. Bangkok: United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific. Available at <http://www.unescap.org/pdd/publications/survey2012/notes/Mongolia.asp>
- UNESCO (2011) World Data on Education 2010-2011: Mongolia, 7th edition. Paris: United Nations Educational, Scientific and Cultural Organization. Available at: <http://unesdoc.unesco.org/images/0021/002113/211308e.pdf>
- UNESCO (2012) UIS Statistics. Montreal: UNESCO Institute of Statistics. Available at: <http://www.uis.unesco.org/Pages/default.aspx>
- Weidman, J.C. (2001) ‘Developing the Mongolia Education Sector Strategy 2000-2005: Reflections of a Consultant for the Asian Development Bank’. New York: Teachers College, Columbia University. Available at: <http://bit.ly/PPKV3w>
- World Bank (2010) ‘Tertiary Education in Mongolia: Meeting the Challenges of the Global Economy’. Mongolia Policy Note, Report 52925-MN. Washington DC: World Bank. Available at: [http://siteresources.worldbank.org/EASTASIAPACIFICEXT/Resources/226300-1279680449418/HigherEd\\_MongoliaSkillsReport.pdf](http://siteresources.worldbank.org/EASTASIAPACIFICEXT/Resources/226300-1279680449418/HigherEd_MongoliaSkillsReport.pdf)
- World Bank (2012) World Development Indicators. Washington DC: World Bank. Available at: <http://data.worldbank.org/data-catalog/world-development-indicators>